



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДАА-2022/15/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

Дархан-Уул аймаг

2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг

түр орлон гүйцэтгэгч: Ш.Мөнхбаяр

Утас: 7037-3089

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 7037-3089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994

Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3.Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4. Материаллаг байдал	14
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
Дараагийн аудитаар анхаарал асуудал байхгүй болно.....	17
4.Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Акт тогтоох.....	17
4.3 Зөвлөмж.....	18
5.Аудитын илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН СУМЫН 6 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.НАРАНЧИМЭГ ТАНАА

Ард. од. дс № 173

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 20 дугаар зүйлийн 20.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР 09020301

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,714,232.00	41,231,477.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31210	Төгрөг	0.00	0.00
33	АВЛАГА	198,000.00	0.00
33500	Бусад авлага	198,000.00	0.00
33510	Байгууллагаас авах авлага	198,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	43,516,232.00	41,231,477.00
35100	Түүхий эд материал	1,409,100.00	1,284,800.00
35130	Эм боох материал	1,409,100.00	1,284,800.00
35400	Хангамжийн материал	42,107,132.00	39,946,677.00
35410	Бичиг хэргийн материал	694,500.00	724,500.00
35420	Аж ахуйн материал	39,978,697.00	37,577,647.00
35450	Барилгын засварын материал	0.00	379,700.00
35460	Хүнсний материал	1,188,635.00	1,264,830.00
35470	Бусад хангамжийн материал	245,300.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,168,667,443.39	2,106,025,938.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,168,667,443.39	2,106,025,938.51
39200	Биет хөрөнгө	1,918,698,433.33	1,856,281,788.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,792,724,036.90	1,792,724,036.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,428,522.70)	(62,640,013.62)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	63,981,792.00	59,199,992.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,149,711.59)	(28,678,701.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,805,130.50	38,089,247.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,342,261.06)	(16,829,503.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	132,261,090.15	134,566,590.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(47,957,250.00)	(60,944,988.80)
39217	Ном	804,129.13	804,129.13
39300	Биет бус хөрөнгө	249,969,010.06	249,744,150.10
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(337,289.94)	(562,149.90)
39303	Бусад биет бус хөрөнгө	249,182,000.00	249,182,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,212,381,675.39	2,147,257,415.51
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	198,000.00	554,661.94
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	198,000.00	554,661.94
41300	Өглөг	198,000.00	554,661.94
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	207,037.62
41360	Бусад өглөг	198,000.00	347,624.32
41361	Байгууллагад төлөх өглөг	198,000.00	0.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	347,624.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,212,183,675.39	2,146,702,753.57
51	Засгийн газрын хувь оролцоо	2,212,183,675.39	2,146,702,753.57
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,182,000.00	249,182,000.00
51101	Өмч:-төрийн		249,182,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,892,050,261.34	1,826,569,339.52
51210	Өмнөх үеийн үр дүн	838,926,773.23	1,892,050,261.34
51220	Тайлант үеийн үр дүн	1,053,123,488.11	-65,480,921.82
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,951,414.05	70,951,414.05
6	НИЙТ ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,212,381,675.39	2,147,257,415.51

DAKERTILLY
"DALAIWAN-AUDIT" CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,565,501,989.00	459,740,137.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,097,509,489.00	1,938,337.35
120	Нийтлэг татварын бус орлого	1,097,509,489.00	1,938,337.35
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,132,773.50	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,240.00	175,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,123,533.50	
120009	Бусад орлого	0.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,061,872,025.50	1,763,337.35
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,504,690.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	467,642,500.00	457,801,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	445,000,500.00	426,178,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	445,000,500.00	426,178,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	350,000.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,642,000.00	30,973,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,642,000.00	30,973,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	483,904,967.39	523,910,027.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	483,904,967.39	523,910,027.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	455,306,034.72	510,454,309.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,833,501.47	347,383,696.00
210101	Үндсэн цалин	294,807,957.47	316,679,564.00
210102	Нэмэгдэл	0.00	6,712,433.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	966,000.00	810,499.00
210104	Урамшуулал	25,059,544.00	23,181,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,928,500.00	48,005,545.86
210201	Тэтгэврийн даатгал	29,129,820.95	33,354,764.28
210202	Тэтгэмжийн даатгал	3,479,230.78	3,847,460.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,655,704.64	2,913,327.09
210204	Ажилгүйдлийн даатгал	605,794.89	688,917.87
210205	Эрүүл мэндийн даатгал	6,057,948.74	7,201,075.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,044,987.65	17,702,501.62
210301	Гэрэл, цахилгаан	4,955,730.00	4,537,678.15
210302	Түлш, халаалт	10,612,158.09	8,180,973.59
210303	Цэвэр, бохир ус	3,477,099.56	4,983,849.88
2104	Хангамж, бараа материалын зардал	14,333,836.21	8,087,200.00
210401	Бичиг хэрэг	903,518.00	1,376,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	559,858.21	624,700.00
210404	Ном, хэвлэл	0.00	94,100.00
210405	Хөг хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн устгал, ариутгал	916,000.00	303,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,954,460.00	5,689,150.00
2105	Нормативт зардал	37,652,934.00	20,879,755.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,688,600.00	828,350.00
210502	Хоол, хүнс	35,167,534.00	19,446,005.00

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	796,800.00	605,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,309,000.00	0.00
210604 ✓	Урсгал засвар	2,309,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,789,030.00	797,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,208,530.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,500.00	580,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	216,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,414,245.39	67,599,010.80
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	445,000.00	99,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,000.00	370,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,918,245.39	67,129,310.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,598,932.67	13,455,218.46
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	47,012.35	6,270,998.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,012.35	6,270,998.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,551,920.32	7,164,220.06
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,551,920.32	7,184,220.08
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,053,123,488.11	(64,169,891.39)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	1,311,031.43
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	1,311,031.43
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,053,123,488.11	(65,480,921.82)

BAKERTILLY
"DALAIWAN-AUDIT" CO., Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	467,651,740.00	457,976,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,240.00	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,240.00	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,240.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,240.00	175,000.00
120009	Бусад орлого	0.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	467,642,500.00	457,801,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	445,000,500.00	426,178,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	445,000,500.00	426,178,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	350,000.00	650,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	650,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	22,642,000.00	30,973,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	22,642,000.00	30,973,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	460,845,740.00	453,941,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	460,845,740.00	453,941,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	432,048,807.33	440,486,081.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	320,833,501.47	346,936,866.30
210101	Үндсэн цалин	258,608,249.47	272,262,107.30
210102	Нэмэгдэл	36,039,252.00	50,683,059.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	966,000.00	810,500.00
210104	Урамшуулал	25,220,000.00	23,181,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,928,500.00	47,897,713.62
210201	Тэтгэврийн даатгал	30,122,059.34	33,226,326.46
210202	Тэтгэмжийн даатгал	2,581,140.66	3,941,293.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,460,000.00	2,895,469.39
210204	Ажилгүйдлийн даатгал	615,000.00	685,553.35
210205	Эрүүл мэндийн даатгал	6,150,300.00	7,149,071.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,044,987.65	17,702,501.62
210301	Гэрэл, цахилгаан	4,955,730.00	4,537,678.15
210302	Түлш, халаалт	10,612,158.09	8,180,973.59
210303	Цэвэр, бохир ус	3,477,099.56	4,983,849.88
2104	Хангамж, бараа материалын зардал	3,202,158.21	2,123,000.00
210401	Бичиг хэрэг	160,000.00	334,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	559,858.21	624,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,577,000.00	944,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	905,300.00	220,100.00
2105	Нормативт зардал	41,883,560.00	20,464,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,170,200.00	207,100.00
210502	Хоол, хүнс	36,233,760.00	19,522,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,479,600.00	735,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,309,000.00	2,964,500.00
210604	Урсгал засвар	2,309,000.00	2,964,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,947,100.00	797,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,366,600.00	0.00

BAKERTILLY
"DALAIYAN-AUDIT"CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,500.00	580,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	216,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	900,000.00	1,599,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	99,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,796,932.67	13,455,218.46
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	198,000.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	198,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	47,012.35	6,270,998.38
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	47,012.35	6,270,998.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,551,920.32	7,184,220.08
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,551,920.32	7,184,220.08
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,004,000.00	4,035,500.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,004,000.00	4,035,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,004,000.00	4,035,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,004,000.00	4,035,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,004,000.00	4,035,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(7,004,000.00)	(4,035,500.00)

BAKERTILLY
"DALAIVAN -AUDIT"CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAIGAL

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	838,926,773.23	1,159,060,187.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	838,926,773.23	1,159,060,187.28
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,053,123,488.11	1,053,123,488.11
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,892,050,261.34	2,212,183,675.39
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,892,050,261.34	2,212,183,675.39
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,892,050,261.34	2,212,183,675.39
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(65,480,921.82)	(65,480,921.82)
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,826,569,339.52	2,146,702,753.57

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Харьцуулалт
ii	НИЙТ ЗАРПАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	456,694,000.00	443,696,581.54	12,997,418.46	97%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,694,000.00	443,696,581.54	12,997,418.46	97%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,694,000.00	443,696,581.54	12,997,418.46	97%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	353,740,800.00	346,936,866.30	6,803,933.70	98%
210101	Үндсэн цалин	296,344,800.00	272,262,107.30	24,082,692.70	92%
210102	Нэмэгдэл	31,210,000.00	50,683,059.00	(19,473,059.00)	162%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,004,800.00	810,500.00	2,194,300.00	27%
210104	Урамшуулал	23,161,200.00	23,161,200.00	0	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,276,500.00	47,897,713.62	378,786.38	99%
210201	Тэтгэврийн даатгал	34,120,600.00	33,226,326.46	894,273.54	97%
210202	Тэтгэмжийн даатгал	3,538,900.00	3,941,293.17	(402,393.17)	111%
210203	ҮСМШӨ-ний даатгал	2,831,200.00	2,895,409.39	(64,209.39)	102%
210204	Ажилгүйдлийн даатгал	707,800.00	685,553.35	22,246.65	97%
210205	Эрүүл мэндийн даатгал	7,078,000.00	7,149,071.25	(71,071.25)	101%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,515,700.00	17,702,501.62	5,813,198.38	75%
210301	Гэрэл, цахилгаан	5,370,800.00	4,537,679.15	833,121.85	84%
210302	Түлш, халаалт	11,281,200.00	8,180,973.59	3,100,226.41	73%
210303	Цэвэр, бохир ус	6,863,700.00	4,983,849.88	1,879,850.12	73%
2104	Хангамж, бараа материалын зардал	1,299,500.00	1,298,000.00	1,500.00	100%
210401	Бичиг хэрэг	160,000.00	159,000.00	1,000.00	99%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	624,700.00	624,700.00	0	100%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	294,200.00	294,200.00	0	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	220,600.00	220,100.00	500	100%
2105	Норматив зардал	20,164,700.00	20,164,700.00	0	100%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	207,100.00	207,100.00	0	100%
210502	Хоол, хүнс	19,522,200.00	19,522,200.00	0	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	735,400.00	735,400.00	0	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,000,000.00	7,000,000.00	0	100%
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00	0	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	797,100.00	797,100.00	0	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		580,500.00	(580,500.00)	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	797,100.00	216,600.00	580,500.00	27%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,599,700.00	1,599,700.00	0	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	99,700.00	99,700.00	0	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00	0	100%

BAKERTILLY
"DALAIYAN -AUDIT" CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	456,694,000.00	443,696,581.54	12,997,418.46	97%
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	426,178,300.00	418,994,079.92	7,184,220.08	98%
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,178,300.00	418,994,079.92	7,184,220.08	98%
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	30,515,700.00	24,702,501.62	5,813,198.38	81%
320001	Орон нутгийн төсвөөс	30,515,700.00	24,702,501.62	5,813,198.38	81%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100%
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100%
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35	0	100%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22	0	100%
620003	Үйлчлэх ажилтан	12	12	0	100%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	312	150	162	48%

BAKERTILLY
"DALAIVAN-AUDIT"CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

2.6 НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		650,000.00	(650,000.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		650,000.00	(650,000.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ			-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил			-
210101	Үндсэн цалин			-
2102	Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл			-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал			-
2104	Хангамж, бараа материалын зардал		650,000.00	(650,000.00)
210401	Бичиг хэрэг			-
210402	Тээвэр, шатахуун			-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		650,000.00	(650,000.00)
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс			-
2105	Нормативт зардал			-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал			-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал			-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ			-
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг			-
2132	Бусад урсгал шилжүүлэг			-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			-
2200	Дотоод эх үүсвэрээр			-
220001	Барилга байгууламж			-
221001	Их засвар			-
222001	Тоног төхөөрөмж			-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		650,000.00	(650,000.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		650,000.00	(650,000.00)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		650,000.00	(650,000.00)
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			-

BAKERTILLY
"DATA AND AUDIT" CO., Ltd
CERTIFIED PUBLIC ACCOUNTING, AUDITING
GENERAL

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Б.Ундаръяа, аудиторын туслах Б.Сувд-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дархан сумын 6 дугаар цэцэрлэг нь “База насны хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжин хүүхдийг эрүүл аюулгүй, ээлтэй орчинд хөгжүүлэх” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 523,910.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,239.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,667.4 мянган төгрөгөөр тогтоосон. Тогтоосон төлөвлөлтийн эрхний материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 65,124.2 мянган төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	198.0		(198.0)
Бараа материал	43,516.2	41,231.4	(2,284.8)
Үндсэн хөрөнгө	2,168,667.4	2,106,026.0	(62,641.4)
Нийт хөрөнгө	2,212,381.6	2,147,257.4	(65,124.2)

Б.А.С.Э.Х.
"DALAIYAN-AUDIT" CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

Өр төлбөр	198.0	554.6	356.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,212,183.6	2,146,702.8	(65,480.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,212,381.6	2,147,257.4	(65,124.2)

Бараа материал дансны үлдэгдэл 2,284.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 27,854.2 мянган төгрөгийн бараа материал бэлтгэсэн, эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А/31 тоот тушаалаар 2,785.7 мянган төгрөгийн бараа материал акталсан, 27,353.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,201.2 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 4,035.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгө бэлтгэсэн, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 59.3 мянган төгрөгийн тоглоомын тавиур үнэ төлбөргүй хүлээн авсан, Орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ний өдрийн А/33 тоот тушаалаар 3,010.0 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг 1,704.0 мянган төгрөгөөр дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоосон, Аймгийн "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн шийдвэрийн дагуу 261.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 1,455.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмж, акталж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэлд тайлант онд өөрчлөлт гараагүй байна.

Өглөг дансны үлдэгдэл 356.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, ажиллагсдад олгох цалингийн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,146,702.8 мянган төгрөг болж 65,480.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос 1,104,031.9 мянган төгрөгөөр буюу 239.2 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө буурсан нь голлон нөлөөлжээ.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 40,005.0 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар нь өссөн нь цалин, НДШ-ын зардал, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнөөс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 680,848.6 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

BAKERTILLY
"DALAIYAN-AUDIT" CO., Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 456,694.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 426,178.3 мянган төгрөгийг улсын төсвөөс *Итүсгай зориулалтын шилжүүлгээр*, 30,515.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 426,178.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 30,973.5 мянган төгрөгийн санхүүжилт авч цахим тендерийн орлого 175.0 мянган төгрөг буюу нийт 457,326.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 443,871.5 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 13,455.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 443,871.5 мянган төгрөг буюу 97.0 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ын зардлыг 7,182.8 мянган төгрөгөөр, тогтмол зардлаас 5,813.2 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСШУЯ-с ариутгал халдваргүйжүүлэлт 650.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан "Түр журам журам батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралт "*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*"-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь 147 мэдээллийг бүрэн оруулсан, 1 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Дархан сумын 6 дугаар цэцэрлэгт 456,694.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 443,871.5 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.6 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,673.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,748.7 мянган төгрөгийн зөрчлийг аудитын явцад залруулж, 2,924.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

BAKERTILLY
“DALAIVAN -AUDIT”CO.,Ltd
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд 554.7 мянган төгрөгийн НДШ, цалингийн өглөгийг тусгаагүй, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг 1,730.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан, цалингийн зардлыг 464.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг тус тус залруулав.

4.2 Акт тогтоох

1. Багш нарт 1,712.3 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг үр дүнгийн урамшуулал олгох үнэлгээгээр үнэлж 20-25 хувиар олгосон нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангиин сайдын хамтарсан 2021 оны 2 дүгээр сарын 01-ний өдрийн А/35 А/10 /9 дүгээр тушаалын 10-д заасан “..... сургуулийн түвшинд амжилт гаргасан бол 10 хувиар, сум дүүргийн түвшинд амжилт гаргасан бол 15 хувиар, аймаг нийслэлийн түвшинд амжилт гаргасан бол 20 хувиар, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан бол 25 хувиар” ур чадварын нэмэгдэл олгоно гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Түр гэрээгээр ажиллаж байгаа ажиллагсад 1,212.0 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал, орон нутагт ажилласны нэмэгдэл, мэргэжлийн зэргийн нэмэгдэл, ТАХ нэмэгдэл зэрэг нэмэгдлүүд олгосон нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно” 4.2-д “Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна” гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7-д гэсэн заалтуудыг зөрчсөн байгаа тул

холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан сумын 6 дугаар цэцэрлэг	6	5,673.0	3	2,748.7	2	2,924.3			1	

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

Дугаар 01/15

Дархан сум

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр багш нарт 1,712,329 төгрөгийн үр чадварын нэмэгдлийг сард 20-25 хувиар тооцож олгосон

Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь "цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.3.3: Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх 1,712,329 /Нэг сая долоон зуун арван хоёр мянга гурван зуун хорин есөн/ төгрөгийг хавсралтад заасан албан хаагчдаар төлүүлж Төрийн сан дахь Да.хүү, торгуулийн 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2022 оны 05-р сарын 01-ний өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Наранчимэгт хариуцуулав..

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Б.УНДАРЪЯА

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009050166



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 05 дугаар сарын 01

Дугаар 01/54

Дархан сум

ТӨЛБӨР НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түр гэрээгээр ажиллаж байгаа ажиллагсад 1,211,991 төгрөгийн улирлын үр дүнгийн урамшуулал, орон нутагт ажилласны, мэргэжлийн зэргийн, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлүүдийг тус тус олгосон.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоно" 4.2-д "Энэ журмын 4.1-д заасан албан хаагч гэдэгт сургалтын байгууллагын төсвөөс цалинждаг орон тооны ажилтан хамаарна" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.3.3: Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх 1,211,991 /Нэг сая хоёр зуун арван нэгэн мянга есөн зуун ерэн нэгэн/ төгрөгийг хавсралтад заасан албан хаагчдаар төлүүлж, Төрийн сан дахь Да.хүү, торгуулийн 100190000988 тоот дансанд төвлөрүүлэх,

2. Актын биелэлтийг 2022 оны 05-р сарын 01-ний өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Наранчимэгт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Б.УНДАРЪЯА

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР



009050170